Говь-Алтай аймгийн өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн илэрлийг судалсан нь

Т.Ганцэцэг[1], П.Энх-Учрал[2], Э.Мягмарцэрэн[3], В.Баярмаа[4], Л.Насанцэнгэл[4]

[1]АШУҮИС, АУС, Сэтгэцийн Эрүүл Мэндийн тэнхим
[2]Тархи судлалын хүрээлэн
[3]АШУҮИС, АУС, Сэтгэцийн Эрүүл Мэндийн тэнхимийн резидент
[4]Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
Цахим хаяг: gantsetseg.t@mnums.edu.mn, Утас: 99064741

Түлхүүр үг:
SDQ- асуумж
Гэр бүл
Найз
Хүүхэд

Товч утга:
Үндэслэл: Сүүлийн хорин жилийн хугацаанд сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн асуудалд өртөх эрсдэлтэй хүүхдүүдийг эрт илрүүлэх асуудалд дэлхий нийт ихээхэн анхаарах болсон. Судлаач В. Баярмаа нарын (2018 он) судалгаагаар манай улсын өсвөр насныхны дунд сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгийн тархалт 8.7%-9.4%[13] байгаа нь өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх, нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг судлах хэрэгцээ шаардлага хот, аймаг бүрт тулгарч байна. **Зорилго:** Говь-Алтай аймгийн өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийг SDQ асуумжийг ашиглаж судлах. **Арга аргачлал:** Бид хүүхэд, өсвөр насныхан, эцэг эх, багш нарт тус бүрт зориулагдсан Strengths and Difficulties Questionnaire (SDQ) асуумжийг ашиглан нэг агшингийн судалгааны аргаар сэтгэл хөдлөл болон зан үйлийн өөрчлөлтийн илрэлийг үнэлсэн. **Үр дүн:** Бидний судалгаанд нийт 2192 хүн хамрагдсан бөгөөд үүний 50.5% (n=1107) нь хөвгүүд, 49.5% (n=1085) нь охид байсан. Судалгаанд хамрагдагсдын сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийг хүүхдүүдийн асуумжийн үнэлгээгээр 40.3% нь хэвийн, 30.3% нь зааг, 29.4% нь хэвийн бус, эцэг эх, асран хамгаалагчийн 42.8% нь хэвийн, 23.9% нь зааг, 33.4% нь хэвийн бус, багшийн нарын 48.2% нь хэвийн, 32.1% нь зааг, 19.7% нь хэвийн бус түвшинд байна гэж тус тус үнэлсэн байлаа. Судалгааны үр дүнс Говь-Алтай аймгийн өсвөр насныхны 58.6% нь эрүүл, 36.1% нь сэтгэл хөдлөл зан үйлийн асуудалтай, 5.2% нь сэтгэл хөдлөл болон зан үйлийн эмгэгтэй байв. **Дүгнэлт:** 1. Судалгаанд хамрагдагсдын сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийг хүүхдүүдийн 40.3% нь хэвийн, 30.3% нь зааг байдалд, 29.4% нь хэвийн бус, эцэг эх, асран хамгаалагчдийн 42.8% нь хэвийн, 23.9% нь зааг байдалд, 33.4% нь хэвийн бус, багш нарын 48.2% нь хэвийн, 32.1% нь зааг байдалд, 19.7% нь хэвийн бус түвшинд байна гэж үнэлсэн байлаа. 2. Харин Говь-Алтай аймгийн өсвөр насныхны 58.6% нь сэтгэцийн хувьд эрүүл, 36.1% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 5.2% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байв.

Үндэслэл: Сүүлийн хорин жилийн хугацаанд сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн асуудалд өртөх эрсдэлтэй хүүхдүүдийг эрт илрүүлэх тал дээр ихээхэн анхаарах болсон. Сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн асуудалтай хүүхэд өсвөр насныхныг үнэлэх нь нийгмийн эрүүл мэндийн асуудал бус, эмнэлзүйн болон судалгааны салбарт ихээхэн чухал юм. Өсвөр нас нь хүний амьдралын хамгийн чухал үеийн нэг бөгөөд энэ үед сэтгэцийн эмгэгээр өвдөх хамгийн өндөр эрсдэлтэй үе юм.[1] Олон улсад SDQ буюу өсвөр насны хүүхдүүдийн давуу ба сул талыг үнэлэх асуумжийг сэтгэцийн болон зан үйлийн тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор

түгээмэл хэрэглэж байна.[2-4] НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцод хүүхэд аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдлаас хамгаалуулах эрхтэй бөгөөд насанд хүртлээ эцэг эх, гэр бүл ба төрийн онцгой халамж, хамгаалалтад байх шаардлагатай болохыг тусгасан[5] бол ДЭМБ-аас дэлхий дээр хүүхэд болон өсвөр насныхны 20% нь сэтгэц, зан үйлийн эмгэгтэй тухай тайланда дурьдсан байдаг.[6-7] Сүүлийн үед хийгдсэн судалгаанаас харахад амиа хорлолт бус өөрийгөө гэмтээх үзэгдэл нь өсвөр насныхны дунд өргөн тархалттай байдаг бөгөөд энэ нь тухайн хүүхдийн зан төлөв, үе тэнгийнхэн болон сургуулийн орчны сөрөг нөлөөлөлтэй шууд хамааралтай байна гэж дүгнэжээ.[8-9] Оросын Холбооны Улсын Сибирь мужид (2007 он) хүүхэд өсвөр насанд сэтгэцийн тулгамдсан асуудал 15-20%[10] гэж тодорхойлсон бол харин Америкийн Нэгдсэн Улсад (2009 он) сургуульд сурч буй өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийн тулгамдсан асуудал 18-22%-тай байгааг цөөнгүй судалгааны ажилд дурьдсан байна.[11] Харин ДЭМБ-аас 2006 онд хийсэн WHO-AIMS үнэлгээгээр манай улс нь хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ байхгүй гэжээ.[12] Судлаач В. Баярмаагийн (2018 он) өсвөр насны хүүхдүүдийн дунд сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгийн тархалт нь эцэг эхийн үнэлгээгээр 8.7%, багшийн үнэлгээгээр 8.8%, хүүхэд өөрийн үнэлгээгээр 9.4%-ийг эзэлжээ.[13] Иймд хот болон хөдөө орон нутагт өсвөр насны хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг үнэлэх, түүнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг судлах хэрэгцээ шаардлага зайлшгүй тулгарч байгаа нь уг судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго: Говь-Алтай аймгийн өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийг SDQ асуумжийг ашиглаж судлах.

Зорилт:

1. Говь-Алтай аймгийн өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийн хэвийн болон зааг, хэвийн бус хэлбэрүүдийг судлах.
2. Говь-Алтай аймгийн өсвөр насныхны дунд сэтгэцийн эрүүл байдал, сэтгэцийн тулгамдсан асуудал болон сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгийн эзлэх хувийг тогтоох.

Арга аргачлал: Судалгааг НҮБ-ийн хүүхдийг ивээх сангийн захиалгаар агшингийн загвараар Говь-Алтай аймгийн 18 сумын 11-18 насны нийт 2192 сурагч болон тэдний 1808 эцэг эх, асран хамгаалагч, анги удирдсан 102 багшийг хамруулсан. Ингэхдээ ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-д суурилж 2018 оны 3 сараас 10 сарын хооронд хийж гүйцэтгэсэн. Уг судалгаанд 100 гаруй оронд ашигласан буй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Strengths and Difficulties Questionnaire (SDQ) стандарт асуумжийн 2017 оны Монгол хувилбарыг ашигласан. *www.SDQinfo.com* хаягаар нэвтэрч танилцах болно.[14,15] Судалгааны материалыг 2 үе шаттай цуглуулсан. I шатанд Говь-Алтай аймгийн ЕБС-ийн багш болон нийгмийн ажилтан зэрэг нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй судлаачийн багийг бүрдүүлж тэдэнд судалгааны асуумж хэрхэн бөглөх талаар сургалт зохион байгуулж судлаач нараа бэлтгэсэн. II шатанд бэлтгэгдсэн судлаач нар аймгийн төв болон хөдөө суманд хуваарилагдан судалгаанд хамрагдсан хүн нэг бүртэй ганцаарчилсан ярилцлага хийж ёс зүйн таниулсан зөвшөөрлийн (№1212-10/1А) хуудсыг танилцуулсны дараа судалгаанд хамрагдагчдаас тусгайлан боловсруулсан асуумжийн дагуу мэдээллийг цуглуулсан. Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг үзүүлэлт тус бүрээр бүлэглэн SPSS 21.0 программыг ашиглаж тойм үзүүлэлтийн аргаар хувьсууруудын эзлэх хувь ба тоон утгыг олж, тоон үзүүлэлтүүдийн тархалт, стандарт хазайлт, дундаж, хамгийн их болон хамгийн бага утгуудыг тооцов.

Үр дүн: Бидний судалгаанд аймгийн төвөөс 249 (11.4%), сумдаас 1943 (11.4%) нийт 2192 хүүхэд хамрагдсаны 50.5% (n=1107) нь хөвгүүд, 49.5% (n=1085) нь охид байсан бол нийт 1808 эцэг эх, асран хамгаалагчийн 69% (n=1247)-ийг эмэгтэйчүүд 31% (n=561)-ийг эрэгтэйчүүд, дундаж нас 40.9±10 байлаа. Харин анги удирдсан 102 багшийн 30.4% (n=31) нь эрэгтэй, 69.6% (n=71) нь эмэгтэй, дундаж нас 34.7±6.4, багшийн мэргэжлээрээ ажилласан жил дунджаар 11.4±6.4, тухайн ангийг удирдаж ажилласан жилийн дундаж 3±1.7 тус тус байв.


Хүснэгт 1. Судалгаанд оролцогч хүүхдийн ерөнхий үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд		Аймгийн төв (n=249)		Сум (n=1943)		Нийт (n=2192)	
		n	%	n	%	n	%
Хүйс	эрэгтэй	127	51.1	980	50.4	1107	50.5
	эмэгтэй	122	48.9	963	49.6	1085	49.5
Ахлах ба дунд бүлэг	Ахлах анги	157	63.1	664	34.2	821	37.5
	Дунд анги	92	36.9	1279	65.8	1371	62.5
Сурлагын дүн	Нийт	n=249		n=1883		n=2133	
	А үнэлгээ	41	16.5	351	18.6	392	18.4
	В үнэлгээ	104	41.8	685	36.4	789	36.9
	С үнэлгээ	78	31.3	573	30.4	651	30.6
	D үнэлгээ	25	10.0	268	14.2	293	13.7
	F үнэлгээ	1	0.4	7	0.4	8	0.4

Хүснэгт 1-ээс харахад аймгийн төвөөс ахлах ангийн сурагчид (n=157, 63.1%), сумдаас дунд ангийн сурагчид (n=1279, 65.8%) харьцангуй идэвхитэй хамрагдсан байна. Сурлагын дүнг судлахад В үнэлгээ (n=789, 36.9%) болон С үнэлгээ (n=651, 30.6%) –тэй хүүхдүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Судалгаанд хамрагдагсдын сэтгэл хөдлөл, зан үйлийн талаар хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш нарын өгсөн үнэлгээний нийт онооны үзүүлэлтээр хэвийн болон зааг, хэвийн бус байдлыг үнэлж үзэхэд: хүүхэд өөрийн үнэлгээгээр 29.4% (n=645) нь "Хэвийн бус", 30.3% (n=664) нь "Зааг", 40.3% (n=883) нь "Хэвийн", эцэг эх, асран хамгаалагчийн үнэлгээгээр 33.4% (n=603) нь "Хэвийн бус", 23.9% (n=432) нь "Зааг", 42.8% (n=773) нь "Хэвийн", багшийн үнэлгээгээр 19.7% (n=426) нь "Хэвийн бус", 32.1% (n=694) нь "Зааг", 48.2% (n=1041) нь "Хэвийн" түвшинд гэж тус тус үнэлжээ.

Бид сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлүүд нь хэр хугацаагаар үргэлжилж байгааг судалж үзэхэд эцэг эх, асран хамгаалагч 26.9%, багш нар 15.4%, хүүхэд 41.1% нь 1 сараас доош хугацаагаар үргэлжилсэн гэж үнэлсэн бол 1-5 сарын хооронд үргэлжилсэн гэж эцэг эх, асран хамгаалагчдын 8.2%, багш нарын 3.1%, хүүхдүүдийн 13.6% нь хариулсан бол эцэг эх, асран хамгаалагчийн 4%, багш нарын 1.7%, хүүхдийн 9.8% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус илрэлүүд 6 сараас дээш хугацаагаар үргэлжилсэн байлаа. Иймд Говь-Алтай аймгийн өсвөр насныхны 58.6% нь сэтгэцийн хувьд эрүүл, 36.1% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 5.2% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байлаа (Зураг 1).



Зураг 1. Сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэл (сар, жил)

Хэлцэмж: судалаач нэр бичих нарын (2019 оны) Хятадын судалгаагаар өсвөр насныхны дунд SDQ-C нь хүйс болон наснаас хамаарсан эквиваленсийг үнэлсэн хэдий ч хугацаанаас хамааруулан харьцуулах боломжгүй байх талтай байжээ[16]. Харин манай орны судлаач В. Баярмаа нарын (2018) орон нутгийн 10 аймаг болон Улаанбаатар хотын 7 дүүргээс нийт 72 сургуулийг сонгон 2250 хүүхэд, 2250 эцэг эх, 72 багшийг хамруулж Монгол улсын өсвөр насныхныг төлөөлөхүйц буюу популяцийн түвшинд хийгдсаэн судалгааны дүнгээс үзэхэд өсвөр насныхны 60.5% нь сэтгэцийн хувьд эрүүл, 30.5% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 9% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байлаа[13]. Харин Говь-Алтай аймгийн өсвөр насныхны 58.6% нь сэтгэцийн хувьд эрүүл, 5.2% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байгаа нь улсын дунджаас бага зэрэг доогуур байгаа хэдий ч сэтгэцийн тулгамдсан асуудалтай (36.1%) хүүхдийн эзлэх хувь улсын дунджаас ялимгүй их байна. Энэ нь Говь-Алтай аймгийн боловсрол-эрүүл мэнд-нийгэм хамгаалал зэрэг салбар хэлтсүүдээс гадна өрх гэр бүл, эцэг асран хамгаалагч нар хүүхдийн хүмүүжилд анхаарах, сурч, амьдрах нөхцөл боломжийг нь сайжруулах, эрүүл аюулгүй орчинд өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлэх шардлага зүй ёсоор тавигдаж байна.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдагсдын сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэлийг хүүхдүүдийн 40.3% нь хэвийн, 30.3% нь зааг байдалд, 29.4% нь хэвийн бус, эцэг эх, асран хамгаалагчдийн 42.8% нь хэвийн, 23.9% нь зааг байдалд, 33.4% нь хэвийн бус, багш нарын 48.2% нь хэвийн, 32.1% нь зааг байдалд, 19.7% нь хэвийн бус түвшинд байна гэж үнэлсэн байлаа.
2. Харин Говь-Алтай аймгийн өсвөр насныхны 58.6% нь сэтгэцийн хувьд эрүүл, 36.1% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 5.2% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байв.

Талархал: Энэхүү судалгааг хийх таатай нөхцөл боломжийг бий болгоход хүн хүч, орчин нөхцөл бүхийл талаар чин сэтгэлээсээ тусалж дэмжсэн НҮБ-ийн хүүхдийг ивээх сан, СЭМҮТ, Говь-Алтай аймгийн тамгын газар болон нийт иргэд нь гүн талархсанаа илэрхийлье.

Ном зүй:

1. *Patel, V., Flisher, A., Hetrick, S., McGorry, P., 2007. Mental health of young people: a global public-health challenge. Lancet 369 (9569), 1302–1313.*
2. *Goodman, R., Ford, T, Simmons, H., Gatward, R., Meltzer, H., 2000. Using the strengths and difficulties questionnaire (SDQ) to screen for child psychiatric disorders in a community sample. Br. J. Psychiatry. 177, 534–539.*
3. *Ortuño, S.J., Aritio, S.R., Fonseca, P.E., 2018. Mental health difficulties in children and adolescents: the study of the SDQ in the Spanish national health survey 2011–2012. J. Psychiatr. Res. 259, 236–242.*
4. *Gustafsson, B.M., Proczkowska, B.M., Gustafsson, P.A., 2017. Emotional and behavioral problems in Swedish preschool children rated by preschool teachers with the strengths and difficulties questionnaire (SDQ). BMC Pediatr 17, 110.*
5. *"НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Тухай Конвенци ба "Байгууллагын хүүхэд хамгааллын бодлого" 2013 он. http://khe.nac.gov.mn/wp-content/uploads/Hentii-huuhed-hamgaalliin-bodlogo.pdf 2021.04. 21*
6. *Organization WH, Association WP, Child IAf, Psychiatry A, Professions A. Atlas: child and adolescent mental health resources: global concerns, implications for the future. World Health Organization; 2005. https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/43307/9241563044_eng.pdf?sequence=1&isAllowed=y. 2021.04.20*
7. *Kieling C, Baker-Henningham H, Belfer M, et al. Child and adolescent mental health worldwide: evidence for action. The Lancet. 2011;378(9801):1515-1525.*
8. *Madjar, N., Ben Shabat, S., Elia, R., Fellner, N., Rehavi, M., Rubin, S.E., Segal,N., Shoval,G., 2017. Non-suicidal self-injury within the school context: multilevel analysis of teachers' support and peer climate. Eur. Psychiatry. https://doi .org/10.1016/j. eurpsy.2016.11.003*
9. *Madjar, N., Zalsman, G., Ben Mordechai, T.R., Shoval, G., 2017. Repetitive vs. occasional non-suicidal self-injury and school-related factors among Israeli high school students. Psychiatry Res.*

https://doi.org/10.1016/j.psychres. 2017.07.073
10. *Slobodskaya HR, Akhmetova OA, Ryabichenko TI. Siberian child and adolescent mental health: Prevalence estimates and psychosocial factors. Alaska medicine. 2007;49(2):261.*
11. *Meltzer H, Gatward R, Goodman R, Ford T. The mental health of children and adolescents in Great Britain. International Review of Psychiatry (2003), 15, 185–187. ISSN 0954–0261 print/ ISSN 1369–1627 online/03/01/20185–03. Crown Copyright DOI: 10.1080/0954026021000046155*
12. *WHO MCO, WHO ROftWP, Abuse WDoMHaS. WHO-AIMS report on Mental Health System in Mongolia, Ulaanbaatar: World Health Organization; 2006.*
13. *В.Баярмаа. Өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийг судалсан судалгаа. Дистертаци. 2019 он. х113.*
14. *www.SDQinfo.com. 2018. 01.13*
15. *Evers, A., Sijtsma, K., Lucassen, W., Meijer, R.R., 2010. The Dutch review process for evaluating the quality of psychological tests: history, procedure, and results. Intern. J. Test. 10, 295–317.*
16. *Liang Lijuana, Yang Juana,*, *Yao Shuqiao. Measurement equivalence of the SDQ in Chinese Adolescents: A horizontal and longitudinal perspective. Journal of Affective Disorders 257 (2019) 439–444*

Studying the emotional and behavioral expression of adolescents in Gobi-Altai prefecture

Gantsetseg T[1], Enkh-Uchral P[2], Myagmartseren E[3], Bayarmaa V[4], L.Nasantsengel[4]

[1]MNUMS, SOM, Mental Health Department
[2]Brain Science Institute
[3]MNUMS, SOM, Mental Health Department, residence
[4]National Center for Mental Health
Email: gantsetseg.t@mnums.edu.mn, Tel: 99064741

Introduction: Previous research has shown that approximately 20% of children and adolescents develop a mental illness at some point in their lifetime. According to the research of Bayarmaa V et al, the prevalence of behavioral and emotional disorder among adolescents is between 8.7% and 9.4%. As a result of these researches, it can be concluded that evaluating the mental health of adolescents and learning the risk factors that can affect it has become an urgent matter in Mongolia.
Objective: Define the emotional and behavioral state of adolescents of Gobi-Altai prefecture by using SDQ.
Material and method: We used various versions of the Strengths and Difficulties Questionnaire (SDQ) applicable for children, adolescents, parents and teachers and determined exhibition of emotional and behavioral problems by cross-sectional analysis.
Results: In our study, 50.5% (n=1107) of participants were boys, 49.5% (n=1085) were girls and totally 2192 participants were involved. Among the study participants, 40.3% of the children self-evaluated their emotional and behavioral state as normal, 30.3% as borderline and 29.45 as abnormal, and 42.8% of the parents and caregivers self-evaluated themselves as normal, 23.9% as borderline and 33.4% as abnormal. Moreover, 48.2% of the teachers self-evaluated themselves as normal, 32.1% as borderline and 19.7% as abnormal. Regarding the survey results, 58.6% of adolescents in Gobi-Altai province were healthy, 36.1% of them had emotional and behavioral problems and 5.2% of them had emotional and behavioral disorders.
Conclusion:
1. Among the study participants, 40.3% of total adolescents evaluated their emotional and behavioral expression as normal, 30.3% as borderline and 29.4% as abnormal. 42.8% of parents and caregivers evaluated as normal, 23.9% as borderline and 33.4% abnormal; 48.2% of teachers evaluated as normal, 32.1% as borderline and 19.7% as abnormal.
2. However, 58.6% of adolescents in Gobi-Altai prefecture were healthy, 36.1% of them had emotional and behavioral problems and 5.2% of them were with emotional and behavioral disorders.

Key words: SDQ- Questionnaire, family, friend, child